



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 4/90

Ховд

Салбар зөвлөлийг шинэчлэн  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 26.1.6-ын "А" заалтыг үндэслэн Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн 2010 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэргэжлийн боловсрол сургалтын талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих үүрэг бүхий салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга - Аймгийн Засаг даргын Нийгмийн бодлого хариуцсан орлогч

Орлогч дарга: - Аймгийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүн

Гишүүд: - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

- Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга

- Аймгийн барилгачдын холбооны тэргүүн

- Үйлдвэрлэл, хоршооллын холбооны тэргүүн

- Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга

Нарийн бичгийн  
дарга:

- "Хөгжил" Политехник коллежийн захирал

2. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/44 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ажлын үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/-д үүрэг болгосугай,

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ